Ковид-19 цар тахлын үеийн оюутнуудын эрүүл мэндийн боловсрол ба амьдралын чанарыг судалсан нь

П.Орхонтуяа[1], Б.Одгэрэл[2], Ц.Дашдулам[3], Я.Энхжаргал[4]

[1,2]АШУҮИС, Сувилахуйн сууулийн ЕЭТ
[3]АШУҮИС, Сувилахуйн сургуулийн АСШУТ
[4]АШУҮИС, Сувилахуйн сургуулийн НЭМСТ
Цахим шуудан: orkhontuya@mnums.edu.mn, Утас: 99993971

Түлхүүр үг:

Эрүүл мэндийн боловсрол
Амьдралын чанар

Товч утга:

Үндэслэл: Ковид-19 вирусийн халдвар 2020 онд дэлхий дахинд тархаж, ДЭМБ-аас цар тахал болсныг зарласан. **Зорилго:** Ковид-19 цар тахлын үе дэх Сувилахуйн Сургуулийн оюутнуудын эрүүл мэндийн боловсролын мэдлэг, хандлагыг тодорхойлох. **Арга, аргачлал:** Судалгааг агшингийн тоон судалгаагаар зорилтот түүврийн аргыг ашиглан Сувилахуйн сургуулийн I дамжааны 271 оюутнуудыг хамруулав. Мэдээ материал цуглуулахдаа цахим хэлбэрээр эрүүл мэндийн суурь боловсролыг үнэлэх 5 асуулт (HL-Health Literacy in School-Aged Children (HLSAC), амьдралын чанарыг тодорхойлох 10 асуулт (HQ-health-related quality of life (HRQoL)-ийг тус тус ашиглав. **Үр дүн:** Судалгаанд оролцогчдын дундаж нас 18.95 (sd=.198), одоогоор 65.7% нь ковид-19 халдвараар өвчлөөгүй эрүүл гэсэн бол 34.3% нь өвдсөн байна. Ковид-19 халдвар туссан оюутнуудын 1.1% нь тусгаарлах байр, 5.5% нь эмнэлэг, 42.4% нь гэртээ тусгаарлагдсан байна. **Дүгнэлт:** Судалгаанд оролцогчдын эрүүл мэндийн боловсрол нь амьдралын чанарын үзүүлэлттэй статистик ач холбогдолтой гарсан.

Үндэслэл: Ковид-19 вирусийн халдвар 2020 онд дэлхий дахинд тархаж, ДЭМБ-аас цар тахал болсныг зарласан[1]. Халдварын тархалтыг зогсоохын тулд гарын эрүүл ахуйг сахих, олон нийтийн дунд зай барих, нүд, ам хамрандаа бохир гараараа хүрэхээс татгалзах, амьсгалын замын халдвараас сэргийлэх, шинж тэмдэг илэрсэн үед эмнэлгийн тусламж авахаас эхлээд нийгмийн эрүүл мэндийн өргөн цар хүрээтэй арга хэмжээ авахыг шаардах болсон[2]. Эрүүл мэндийн харилцаа гэдэг нь хүмүүсийг корно вирусийн талаарх мэдээллээр хангах, эрүүл мэндийн боловсрол олгох, вирус улам өргөн хүрээнд тархахаас сэргийлэх арга хэмжээ юм[3]. Хэдийгээр өсвөр насныхан энэ вирусийн халдвар авч өвдөх магадлал бага боловч шинж тэмдэг илрэхгүйгээр вирусийг тараах магадлал өндөртэй, иймд тэднийг вирусийн тархалтаас хамгаалах шаардлагатай мэдээллээр хангах нь чухал ач холбогдолтой. Эрүүл мэндийн боловсролтой холбоотой амьдралын чанарын үзүүлэлтүүд гэдэгт бие махбод, сэтгэл санаа болон нийгмийн үйл ажиллагааг хамруулсан, эрүүл мэндтэй хамааралтай үзүүлэлтүүд нь тухайн хүний хувьд хэр хангалттай байгаагаар тодорхойлогдоно. Анх цар тахлыг зарласнаас хойш сургалтын болон бусад чөлөөт цагаа өнгөрүүлэх байгууллагууд хаагдсанаар өсвөр насныхны ганцаардал, бусдаас тусгаарлагдах, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжууд хязгаарлагдсан[2]. Ийм нөхцөлд вирусийн халдварын тархалтыг зогсоохын тулд тогтоосон зай барих, хөл хорионы дэглэмүүд нь өсвөр насныхны эрүүл мэндтэй хамааралтай амьдралын чанарын үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлөх талтай байж болох юм. Судлаачдын судалгааны үр дүнгээс харахад өсвөр насныхны эрүүл мэндийн боловсролтой холбоотой амьдралын чанарын үзүүлэлтүүдийн талаар бага судлагдсан байв. Бид энэхүү судалгаагаар Ковид-19 цар тахлын үе дэх Сувилахуйн Сургуулийн оюутнуудын эрүүл мэндийн боловсрол ба амьдралын чанарын хоорондын хамаарлыг тодорхойлох болно.

Зорилго: Ковид-19 цар тахлын үе дэх Сувилахуйн Сургуулийн оюутнуудын эрүүл мэндийн боловсролын мэдлэг, хандлагыг тодорхойлох

Зорилт:

1. Ковид-19 цар тахлын үе дэх Сувилахуйн

Сургуулийн оюутнуудын эрүүл мэндийн боловсролыг судлах
2. Оюутнуудын эрүүл мэндийн боловсрол ба амьдралын чанарын хоорондын хамаарлыг судлах

Арга, аргачлал: Судалгааг нэг агшингийн загвараар тоон судалгааны аргыг ашиглан зорилтот түүврийн аргаар АШУҮИС-ийн Сувилахуйн Сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийн 1-р улиралд суралцаж байгаа I дамжааны 271 оюутнуудыг хамруулав. Судалгаанд сувилахуйн ангийн 173 (63.9%), тусгай мэргэжил (лабораторийн техникч, дүрс оношлогооны техникч, эм найруулагч, нүүр амны техникч, дипломын сувилагч)-ийн 98 (36.1%) оюутан тус тус хамрагдав.

Судалгааны асуумжийг цахим хэлбэрээр google form ашиглан олон улсад туршигдсан, нээлттэй хандалттай стандарт асуумжийг ашиглан судалгааг явуулсан. Мэдээ материал цуглуулахдаа эрүүл мэндийн суурь боловсролыг үнэлэх 5 асуулт (HL-Health Literacy in School-Aged Children (HLSAC)[1,4], амьдралын чанарыг тодорхойлох 10 асуулт (HQ-health-related quality of life (HRQoL)[5]-ийг тус тус ашиглав. Судалгааны мэдээ материал цуглуулсан стандарт асуумжийг англиас монгол хэл рүү 2 орчуулагч, монгол хэлнээс англи хэл рүү дахин 2 орчуулагч орчуулж үг найруулгын агуулгын алдааг зассаны дараа урьдчилан 20 оюутнаас асуумжийг авч найдвартай хүчин төгөлдөр байдлыг Кронбах альфа коэффициентоор шалгаж 0.95 үнэлгээтэй судалгаанд ашиглав.

Судалгаанд оролцогчдын цахим асуумжийн үр дүнд статистик боловсруулалт хийж, дундаж утгын статистик магадлал бүхий ялгааг 95 хувийн итгэх хязгаараар баталгаажуулав. Оролцогчдын эрүүл мэндийн боловсрол ба амьдралын чанарын хоорондын хамаарлыг шугаман Пирсоны хамаарлын коэффициентийг тооцоолов. Хамаарлын коэффициентыг үнэлэхдээ (-1;0:+1) хооронд үнэлэв.
Судалгааны ажлын ёс зүйн зөвшөөрөл: АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2021 оны 06 сарын 18-ны өдрийн №2021/3-08 хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсан ба хурлын шийдвэрээр батлагдсан зөвшөөрлийн танилцуулгыг google form-д байршуулан оролцогчдод таниулан судалгаанд хамруулсан.

Үр дүн: Сувилахуйн сургуулийн I дамжааны оюутнуудыг хамруулсан судалгаанд нийт 271 оюутан оролцсоны 92.3% нь эмэгтэй, 7.7% эрэгтэй, дундаж нас 18.95 (sd=.198) байлаа. Судалгаанд оролцогчдын 65.7% нь одоогоор ковид-19 халдвараар өвчлөөгүй эрүүл, 34.3% нь өвдсөн байна. Ковид-19 халдвар туссан оюутнуудын 1.1% нь тусгаарлах байр, 5.5% нь эмнэлэг, 42.4% нь гэртээ тусгаарлагдсан байна. Гэртээ тусгаарлагдсан оюутнуудад ковид-19 тусаагүй боловч хөл хорионы үед гэрээр тусгаарлагдаж байсан оюутнуудын хувь нэмэгдэж тооцогдсон. Судалгаанд оролцогчдыг үндсэн харьяаллаар нь ангилж үзвэл Улаанбаатар хот 41.7%, орон нутгийн оролцогч 58.3%-ийг эзэлж байна (Хүснэгт 1). Эцэг эхийн боловсролын түвшний хувьд дээд 22.1%, бүрэн дунд 59.0%, 18.8% нь дунд болон бага боловсролтой байна. Эцэг эхийн боловсролын түвшин болон ковид-19 халвараар өвчилсөн эсэх нь хооронд мэдэгдэхүйц ялгаа байгаагүй. Эрүүл мэндийн боловсролын талаарх мэдээллийг 40.2% нь фэйсбүүк, 35.4% нь зурагт, 19.2% нь гэр бүл, 5.2% нь бусад эх сурвалжаас авдаг байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагсдын хүн ам зүйн мэдээлэл

Судалгаанд оролцогч		N (%)
		271
Хүйс	Эмэгтэй	250 (92.3)
	Эрэгтэй	21 (7.7)
Нас	16 -17 нас	27 (9.7)
	18 -19 нас	213 (78.6)
	20-оос дээш	31 (11.5)
Эрүүл мэндийн байдал	Ковид-19 халдвар авсан	93 (34.3)
	Ковид-19 халдвар аваагүй	178 (65.7)
Тусгаарлагдсан байдал	Тусгаарлах байр	3 (1.1)
	Эмнэлэг	15 (5.5)
	Гэртээ	97 (35.8)
Харьяалал	Улаанбаатар	113 (41.7)
	Орон нутаг	158 (58.3)
Эцэг, эхийн боловсролын түвшин	Дээд	
	Бүрэн дунд	
	Дунд болон бага боловсролтой	
Мэдээллийн эх үүсвэр	Фэйсбүүк	109 (40.2)
	Гэр бүл	96 (35.4)
	Зурагт	52 (19.2)
	Бусад эх сурвалж	14(5.2)

Хүснэгт 2. Эрүүл мэндийн боловсрол, амьдралын чанарын үзүүлэлт хоорондын хамаарал

	Амьдралын чанар оноо (r)	P утга
Эрүүл мэндийн мэдээлэл олж авах чадвар	0.555	p<0.001
Эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн буруу зөвийг шийдэх чадвар	0.606	p<0.001
Эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн буруу зөвийг шийдэх чадвар	0.527	p<0.001
Эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг бусад эх сурвалжтай харьцуулах чадвар	0.536	p<0.001
Өөрийнхөө хийсэн үйлдэл хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх чадвар	0.607	p<0.001
Хэн нэгний эрүүл мэнд хэрхэн сайжруулах талаар санал өгөх чадвар	0.673	p<0.001

Тайлбар: *$^{***}p < .001$*

Эрүүл мэндийн боловсрол болон амьдралын чанарын үзүүлэлтийн хоорондын хамаарлыг тооцож үзэхэд ойлгоход амар эрүүл мэндийн мэдээлэл олж авах чадвар нь (r=.555), эмч болон сувилагч нарын зааврыг дагах нь мөн (r=.606), эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн буруу зөвийг шийдэх чадвар нь (r=.527), эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг бусад эх сурвалжтай харьцуулах чадвар нь (r=.536), өөрийнхөө хийсэн үйлдэл хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх чадвар (r=.607), хэн нэгний эрүүл мэнд хэрхэн сайжруулах талаар санал өгөх чадвар (r=.673) байсан нь (p<0.001) бөгөөд хамгийн хүчтэй хамааралтай үзүүлэлт байлаа.

Хэлцэмж: Ковид-19-н цар тахлын үед Сувилахуйн сургуулийн оюутнуудын эрүүл мэндийн боловсрол нь амьдралын чанарын үзүүлэлттэй статистик ач холбогдолтой эерэг хамаарал бүхий байв. Энэхүү үр дүн нь 16-18 насны Норвегийн өсвөр насныханы судалгааны үр дүнтэй дүйж байв[7]. Судлаачдын судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын ихэнх нь эрүүл мэндийн боловсролын талаар фэйсбүүк, сошиал медиагаас авч байсан нь манай судалгааны үр дүнтэй нийцэж байв.

Ихэнх судалгаанд оролцогчид нь гар угаах, нийгмээс тусгаарлахтай холбоотой хамгаалалтын арга хэмжээний удирдамжийг дагаж мөрддөг гэжээ. Нийгмээс зай барих тусгаарлах нь Ковид-19-н халдварын цар тахлыг бууруулах өндөр ач холбогдолтойг бусад судалгааны ажлуудын үр дүнгүүд харуулсаар байна[8-10]. Монгол улсад хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад өсвөр насныхны эрүүл мэндийн боловсролтой холбоотой амьдралын чанарын үзүүлэлтүүдийн талаар харьцангуй бага судлагдсан байв. Судалгаа нь зөвхөн АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн оюутнуудын дунд хийгдсэн тул бусад зорилтот бүлгийг төлөөлөх боломжгүй юм.

Дүгнэлт: Судалгаанд Ковид-19-н цар тахлын үед Сувилахуйн сургуулийн оюутнуудын эрүүл мэндийн боловсрол нь амьдралын чанарын үзүүлэлттэй статистик ач холбогдолтой эерэг хамаарал бүхий байв. Судалгааны үр дүнд үндэслэн эрүүл мэндийн боловсролоор дамжуулан амьдралын чанарыг сайжруулах боломжтой гэж дүгнэв.

Ном зүй:

1. *World Health Organization. WHO announces COVID-19 outbreak a pandemic [Available from: http:// www.euro.who.int/en/health-topics/health-emergencies/coronavirus-covid-19/news/news/2020/3/who-announces-covid-19-outbreak-a-pandemi.2021. Oct.01*
2. *Guo S, Armstrong R, Waters E, Sathish T, Alif SM, Browne GR, et al. Quality of health literacy instruments used in children and adolescents: a systematic review. BMJ open. 2018; 8(6): e020080–e. https://doi.org/10.1136/bmjopen-2017-020080 PMID: 29903787. 2021. Sep. 22*
3. *National Survey. 2016. 2016; 4(3):11. 8. Fegert JM, Vitiello B, Plener PL, Clemens V. Challenges and burden of the Coronavirus 2019 (COVID-19) pandemic for child and adolescent mental health: a narrative review to highlight clinical and research needs in the acute phase and the long return to normality. Child and Adolescent Psychiatry and Mental Health. 2020; 14(1):20.*
4. *Nutbeam D. Health literacy as a public health goal: a challenge for contemporary health education and communication strategies into the 21st century. Health Promotion International. 2000; 15(3):259–67. 4*
5. *Paakkari O, Torppa M, Ka L, Paakkari L. Subjective health literacy: Development of a brief instrument for school-aged children. Scand J Public Health. 2016; 44(8):751–7. https://doi.org/10.1177/ 1403494816669639 PMID: 27655781 14. 2021.Sep. 25*
6. *The KIDSCREEN Group Europe. The KIDSCREEN questionnaires. Quality of life questionnaires for children and adolescents Lengerich, Germany: Pabst Science Publishers; 2006. p.12*
7. *Riiser K, Helseth S, Haraldstad K, Torbjrnsen A, Richardsen KR (2020) Adolescents' health literacy, health protective measures, and health-related quality of life during the Covid-19 pandemic. PLoS ONE 15(8): e0238161. https://doi.org/10.1371/journal.pone.0238161. 2021 Dec 07*
8. *Keskinocak P, Oruc BE, Baxter A, Asplund J, Serban N (2020) The impact of social distancing on COVID19 spread: State of Georgia case study. PLoS ONE 15(10): e0239798. https://doi.org/10.1371/journal.pone.0239798.2021. Dec 07*
9. *Hartley DM, Perencevich EN. Public Health Interventions for COVID-19: Emerging Evidence and Implications for an Evolving Public Health Crisis. JAMA. 2020. pmid:32275299. 2021.Dec. 07*
10. *Valdez LD, Macri PA, Braunstein LA. Intermittent social distancing strategy for epidemic control. Physical review E: Statistical, nonlinear, and soft matter physics. 2012;85(3 Pt 2):036108. Epub 2012/05/17. pmid:22587150.2021. Dec. 07*

Study of Health Literacy and health-related quality of life among nursing students

Orkhontuya P[1], Odgerel B[2], Dashdulam Ts[3], Enkhjargal Ya[4]

[1,2]Department of Basic Science, School of Nursing, MNUMS
[3]Department of Basic Medical Sciences, School of Nursing, MNUMS
[4]Public Health nursing department, School of Nursing, MNUMS
E-mail: orkhontuya@mnums.edu.mn, Tel: +976 99993971

Introduction: The Covid-19 virus has spread worldwide in 2020, and the World Health Organization has declared it a pandemic. In this study, we identified a link between health education and quality of life of nursing school students during the Kovid-19 epidemic.
Materials and Methods: The survey covered 271 first-year students at the School of Nursing using a one-time quantitative survey using a targeted sampling method. Data were collected using five HL-Health Literacy in School-Aged Children (HLSAC) questions and 10 HQ-health-related quality of life (HRQoL) questions.
Results: The average age of the study participants was 18.95 (sd = .198), of which 65.7% were currently healthy and 34.3% were ill. Of the students infected with Covid-19, 1.1% were housed in isolation shelters, 5.5% in hospitals, and 42.4% at home.
Conclusion: In this study, we will identify the relationship between health education and quality of life of nursing school students during the Coved-19 epidemic.

Keywords: Health education and quality of life